



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№30 /474/

2023.02.10

Цаг үе, үйл явдал

"ХААНЫ ЭРЭЛД-2023" СУРГУУЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ДУНД ШАТНЫ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



"Хааны эрэлд-2023" энхийг сахиулах ажиллагааны олон улсын хэргийн сургуулийн төлөвлөлтийн дунд шатны хурал өнөөдөр ЗХЖШ-д зохион байгуулагдлаа.

Энэ жилийн "Хааны эрэлд" сургуулийг Монгол Улсын Зэвсэгт хүчин болон АНУ-ын Номхон далайн цэргийн командлалтай хамтран явуулахаараа онцлог бөгөөд энэ удаагийн хурлаар төлөвлөлт, зохион байгуулалт, сургуулийн үеэр

хэрэгжүүлэх арга хэмжээг тодотголоо.

Тус хуралд ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд, тасгийн дарга дэд хурандаа Б.Энхцаг, АНУ-ын Номхон далайн цэргийн командлалын Хавай дахь 8 дугаар Цэргийн цагдаагийн бригадын захирагч хурандаа Чарлэс Грийн, сургуулийн удирдагч, тус бригадын штабын дарга дэд хурандаа Жонатан Ясуда, АНУ-аас

Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалах хамтын ажиллагааны хэлтсийн дарга хошууч Рэнэ Бэн Порт, БНТУ-аас Монгол Улсад суугаа Батлан хамгаалахын атташе хурандаа Өзгүр Назым Унсал, Япон Улсаас Монгол Улсад суугаа Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Ирики Ёохэй нар болон бусад албаныхан оролцлоо.

Дэслэгч Т.ИДЭР

ЗХЖШ АХМАДУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Билгийн тооллын XVII жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх Усан туулай жилийн сар шинийн баярыг угтаж ЗХЖШ-аас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмадууддаа хүндэтгэл үзүүллээ.

Тус үйл ажиллагааны эхэнд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр Зэвсэгт хүчний 2022 онд хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар мэдээлэл хийсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Энхийн төлөө", Ардын хувьсгалын болон Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль хүртсэн, Батлан хамгаалахын сайдын тушаалаар шагнагдсан ахмадуудад шагнал гардууллаа.

ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тус үйл ажиллагааны үеэр хэлсэн үгэндээ "Эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах, төрийн цэргийн мэргэжлийн дээд байгууллагыг төлөвшүүлэх, Зэвсэгт хүчний хөгжүүлэн бэхжүүлэх үйл хэрэгт мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвар, хөдөлмөр, зүтгэл, залуу насаа зориулсаар ирсэн эрхэм та бүхэндээ сар шинийн мэндийг урьдчилан дэвшүүлье. Улиран одож буй сайжруулагч хэмээх Усан бар жилд Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний хувьд бахдам амжилт, бахархам гавьяа, бүтээлч үйл ажиллагаагаар манлайлсны дотор Төрийн

цэргийн шинэчлэлийн бодлогыг эрчимжүүлэх, стратегийн болон удирдлагын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлэх, Цэргийн нийтлэг дүрмийг шинэчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаар батлуулах, түүний хэрэгжилтийг хангах ажлыг эхлүүлэх, удирдах газрын бие даасан ажиллагааг хангах, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг төлөвшүүлэн хөгжүүлэх үйл хэрэгт томоохон амжилт гаргасан он жилүүдийн нэг байсныг эрхэм та бүгдэд дуулгахад таатай байна" хэмээгээд хүрэлцэн ирсэн ахмад дайчид болоод ахмадуудад эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөлөө.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-23

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,509	3,513
EUR	3,784	3,800
CNY	517	519
RUB	47.60	48.20
JPY	26.75	26.95
KRW	2.81	2.84

ЗУРХАЙ



2023.02.10 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 20

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.07-18.05

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Авахуй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махаши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 677,122,790

Эдгэрсэн

Нийт: 649,641,470

Нас барсан

Нийт: 6,779,307

Цахим шууданд

ДАЙН, ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧДЫН ХОРОО БОЛЖ ШИНЭЧЛЭГДЛЭЭ



Дайнд оролцогсдын Монголын хороог Дайн, энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын хороо болгон шинэчлэн зохион байгуулах хурал Офицеруудын ордны Соёлын төв өргөөнд боллоо. Тус хуралд Ирак, Афганистан,

Монголын хороо нь Ардын хувьсгалын партизануудыг нэгтгэсэн байгууллагаас эхтэй бөгөөд эх орныхоо тусгаар тогтнол, ард түмнийхээ эрх чөлөө, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдал, энх цагийн бүтээн

1940-1948 оны Баруун хилийн зэвсэгт тулгаралтад оролцсон ахмад дайчид цагийн эрхээр цөөрсөөр байгаа бол олон улсын болон энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын тоо жилээс жилд нэмэгдэж хэдэн мянгад хүрээд байна. Энэ нь дайн, цэргийн ажиллагаанд оролцогчдын байгууллагад дараа, дараагийн үеийнхнийг хамруулж ирсэн уламжлалын дагуу өмнөх байгууллагаа шинэчилж өөрчлөн зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж байна. Тиймээс дээрх хороог Дайн, энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын хороо болгон өөрчлөх тухай асуудлыг Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагад танилцуулан Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн" гэлээ.

Мөн хурлын тэргүүлэгчдээр чөлөөнд байгаа хурандаа Г.Лүндэн, ҮБХИС-ийн зөвлөх профессор, бэлтгэл хошууч генерал Я.Чойжамц, БХЭШХ-гийн судлаач, доктор, профессор бригадын генерал Ц.Гандорж, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат, ЗХЖШ-ын тэргүүн ахлагч асан Д.Энхбаяр нарыг нэр дэвшүүлж, дэмжлээ.

Мандатын комиссын илтгэлийг уг комиссын дарга бригадын генерал Ц.Гандорж тавьсан бол "Дайнд оролцогсдын Монголын хороог Дайн, энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын хороо болгон өөрчлөх шаардлага, үндэслэл" илтгэлийг чөлөөнд байгаа хурандаа Г.Лүндэн, шинэ хорооны дүрмийн төслийн талаар бригадын генерал Б.Эрдэнэбат нар танилцууллаа.

Хурлын дэгийн дагуу оролцогчид тодорхой асуудлуудыг хөндөж, хэлэлцүүлэг өрнүүлсний дараагаар Удирдах зөвлөлийн анхдугаар хурлыг зохион байгуулж, Хяналтын зөвлөлийг сонгож баталгаажуулсан юм.

Энэ үеэр Дайн, энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын хорооны тэргүүнээр бэлтгэл хошууч генерал Я.Чойжамц, дэд тэргүүнээр бэлтгэл хошууч генерал Б.Баярмагнай, Ерөнхий нарийн бичгийн даргаар чөлөөнд байгаа хурандаа Г.Лүндэн нар сонгогдлоо. **Дэслэгч Т.ИДЭР**



Косово, Сьерра-Леон, БНЕСУ, Хойд Судан, Конго, Баруун Сахар, Гүрж, Этиоп-Эритрей зэрэг улсад явагдсан болон одоо явагдаж буй энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүний төлөөлөл оролцлоо.

Хурлыг нээж Дайнд оролцогсдын Монголын хорооны дарга чөлөөнд байгаа хурандаа Г.Лүндэн тус хороо болон Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон, цэргийн багийг удирдаж байсан ахмад ажилтнуудын хамтарсан санаачилгаар энэхүү хурлыг зохион байгуулж байгааг онцлов.

Дайнд оролцогсдын

байгуулалтын төлөө зүтгэж, тэмцэж ирсэн дараа дараагийн үеийнхнээр эгнээгээ өргөтгөж, тухайн цаг үедээ тохирсон нэрээр шинэчлэгдэж иржээ. Монгол Улсын төр, засгийн шийдвэрээр Зэвсэгт хүчин, төрийн цэргийн болон хууль сахиулах бусад байгууллагын алба хаагчид энхийг дэмжих ажиллагаанд үүргээ нэр төртэй гүйцэтгэсээр 20 гаруй жилийг ардаа үдсэн. Монгол цэрэг-Дэлхийн цэрэг болсноор Олон улсын хамтын нийгэмлэг, улс орнуудаас сайшаал, дэмжлэг хүртэж байгаа билээ.

Чөлөөнд байгаа хурандаа Г.Лүндэн "1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн,

Гэрэл зураг-нэг агшин

АВТО ЗАМЫН ИНЖЕНЕР МЭРГЭЖЛЭЭР ЗУРГААН АХЛАГЧ СУРАЛЦАЖ ТӨГСӨВ



Зэвсэгт хүчний Жанжин штаб, Техник Технологийн дээд сургууль 2019 оноос цэргийн алба хаагчдыг нийгэмд эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр сургаж мэргэшүүлэхэд хамтран ажиллаж байгаа билээ. Энэ нь мэдлэг, мэргэшил, боловсролын зэргийг нь

Ахлах ахлагч Л.Хүчитбаатар (256), ахлах ахлагч Ц.Баатархүү, Д.Энхбаяр, Ц.Ганхуяг, н.Мөнхболор (150) болон бэлтгэл сургагч ахлагч Т.Энхбаатар нар 2019-2023 онд тус дээд сургуульд авто замын инженер мэргэжлээр



ахиулах, инженерийн чиглэлд түлхүү сургах, тэтгэвэрт гарах алба хаагчдад нийгэмд хэрэгцээтэй мэргэжил эзэмшүүлэх, хугацаат цэргийн алба хаагчдыг богино хугацааны сургалтад хамруулах зэрэг зорилготой юм.

2019 онд Монгол Улсын Зэвсэгт хүчин стратегийн бүтээн байгуулалтад оролцож эхэлсэнтэй холбогдуулан 50 гаруй цэргийн алба хаагчийг авто зам, барилга угсралтын техникч мэргэжлээр сургаж бэлтгэсэн бөгөөд энэ үед тэдний зарим ахлагч бакалаврын зэрэгтэйгээр үргэлжлүүлэн суралцсан юм.

үргэлжлүүлэн суралцаж, 2023 оны 2 дугаар сарын 10-ны энэ өдөр ромбо, дипломоо багш нараасаа гардан авсан байна.

Тус сургуулийнхан цэргийн алба хаагчдын идэвх оролцоо, хичээл зүтгэл өндөр байсныг онцолж, цаашдаа офицер, ахлагчаас гадна цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчдад мэргэжил олгох, төрөл бүрийн богино хугацааны сургалтыг явуулах боломжтой гэдгээ илэрхийлжээ.

Ахмад Д.БОЛОР

Цахим шууданд

ХЭЭРИЙН ЭМНЭЛГЭЭ ДЭЛГЭЖ БАЙНА



БНТУ-д үүрэг гүйцэтгэж байгаа манай цэргийн алба хаагчид орон нутгийн иргэдтэй англи болон төрөлх хэлээр нь чөлөөтэй харилцаж, газар хөдлөлтөд нэрвэгдсэн нутгийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хээрийн эмнэлгээ дэлгэх

ажил ид өрнөж байна. Зовж зүдэрсэн хүмүүст хүмүүнлэгийн тусламж, бараа, материал нэн яаралтай хэрэгцээтэй байгаа болохоор боломжтой бүхнээр туслаж байна. Ажлын байр бэлэн болмогц эмнэлгийн тусламж үзүүлэх үндсэн ажилдаа орно.



Төр минь төвшин
Түмэн олон минь амгалан байг